

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Улаан-овоо нүүрсний уурхайн үйл ажиллагаа.....	5
1.3. Машин механизм, тоног төхөөрөмж	7
Хүнд машин механизмын засварын цех.....	7
Тоног төхөөрөмж	7
1.4. Агуулахын аж ахуй	8
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	9
2.1. Уур амьсгал.....	9
2.2. Газар зүйн тогтоц.....	9
2.3. Геологийн тогтоц.....	10
2.4. Гадаргын усан сүлжээ	11
2.5. Гидрогеологийн нөхцөл	11
2.6. Хөрсөн бүрхэвч.....	11
2.7. Газар эдэлбэрийн байдал.....	11
2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг	12
2.9. Ургамалжилтын төлөв байдал	12
2.10. Амьтны аймаг	12
3. ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
3.1. Байгалийн орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөлөл	12
3.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл	13
3.3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл	13
3.4. Усан орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	14
3.5. Ургамалан нөмрөгт үзүүлж болзошгүй нөлөөлөл	14
3.6. Амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл	14
3.7. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл	15
3.8. Түүх соёлын өвд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	15
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	15
4.1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд	15
4.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах зөвлөмж.....	16
4.3. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж.....	16
4.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж ..	16
4.5. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж	17
4.6. Ургамалан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж.	17

**“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024**

4.7. Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зөвлөмж.....	18
4.8. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалт зүйлд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж.....	18
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	18
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (ТЕХНОЛОГИЙН, БИОЛОГИЙН)	24
8. ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН.....	25
9. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
10. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	27
11. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
12. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	30
14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	33
15. БОМТ БИЕЛЭЛТИЙГ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	34

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-022059 тоот тусгай зөвшөөрлийн солбицол	4
Хүснэгт 2. 2024 оны нүүрс олборлолтын төлөвлөгөө.....	5
Хүснэгт 3. Улаан-Овоогийн нүүрсний ордын нөөцийн тооцоо /2024.01.01-ний байдлаар/......	5
Хүснэгт 4. Дотоод тээврийн ажлын нэгдсэн дүн.....	6
Хүснэгт 5. Уурхайн агуулахын аж ахуйн байгууламжууд	8
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
Хүснэгт 7. 2024 онд эвдрэлд өртөх талбайн хэмжээ	24
Хүснэгт 8. 2024 онд хийгдэх нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	25
Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	26
Хүснэгт 10. Хаягдсан карьерын координат	26
Хүснэгт 11. Археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтад авах арга хэмжээ.....	27
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	28
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	31
Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	33
Хүснэгт 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	34
Хүснэгт 17. Байгаль орчныг хамгаалах нийт зардал	34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улаан-Овоогийн нүүрсний уурхайн ерөнхий байдал	3
Зураг 2. Төслийн талбайн байршил	4
Зураг 3. Засвар техник үйлчилгээний барилга байгууламж	7
Зураг 4. Эвдрэлд орсон газар	26

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН НЭР:

Улаан-овоогийн нүүрсний ордыг ашиглах төсөл

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР:

Канад улсын 100%-ийн хөрөнгө оруулалттай “Юү Жи Эл Интерпрайзис” ХХК

Регистр: 5002265

Дугаар: 9019001016

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, Гандан, Амарсанаагийн гудамж, 12-1, Хатансүлжээ ХХК-ийн байрны Б корпус 101 тоот

Утас: 312721

ТӨСЛИЙН БАЙРШИЛ:

Улаан-Овоогийн нүүрсний орд нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун тийш 7 км, Сүхбаатар хотоос 107 км, Шаамарын төмөр замын өртөөнөөс 120 км зайд Зэлтэрийн голын хөндийд байрлана.

Зураг 1. Улаан-Овоогийн нүүрсний уурхайн ерөнхий байдал



1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Улаан-Овоогийн нүүрсний орд газар нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун тийш 7 км, төмөр замын Шаамар өртөөнөөс баруун тийш 120 км, Улаанбаатар хотоос 430км, Монгол Оросын Зэлтэр хилийн боомтоос баруун өмнө зүгт 17 км-т оршино. Улаан-Овоогийн нүүрсний орд байрлах Сэлэнгэ аймгийн Түшиг сум нь хойд талаараа ОХУ-ын Буриадын автономит улстай, баруун талаараа Булган аймгийн Бугат сум, зүүн болон урд талаараа Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумтай тус тус хиллэнэ.

Улаан-Овоогийн нүүрсний орд газар нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт 175,74 га талбайг эзлэн “Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь MV-022059 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2022 оноос эхлэн эзэмшиж ирсэн. Уг тусгай зөвшөөрөл нь 2022 оноос өмнө “Рэдхил Монголия” ХХК-ийн эзэмшлийн MV-001231 тоот тусгай зөвшөөрөлд 37.76 га талбай үлдэж “Юү Жи Эл

**“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024**


Интерпрайзис” ХХК-ийн MV-022059 талбайд 175.75 га талбай шилжсэн байдаг. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдэд координатуудыг доор үзүүлэв.

Хүснэгт 1. MV-022059 тоот тусгай зөвшөөрлийн солбицол

№	Газарзүйн солбилцол		Тэгш өнцгийн солболцол	
	X	Y	X	Y
1	104°58'38.050"E	50°19'26.950"N	498379.5741	5574672.75
2	104°58'38.040"E	50°18'48.950"N	498379.0174	5573499.07
3	104°58'26.160"E	50°18'48.950"N	498144.058	5573499.148
4	104°58'17.590"E	50°18'48.950"N	497974.5629	5573499.21
5	104°58'10.950"E	50°18'51.940"N	497843.2652	5573654.123
6	104°58'4.100"E	50°18'26.950"N	497707.8013	5573591.668
7	104°58'0.460"E	50°18'26.950"N	497635.8351	5573644.515
8	104°57'56.610"E	50°18'26.950"N	497559.732	5573729.178
9	104°57'51.470"E	50°18'26.950"N	497458.1073	5573788.528
10	104°57'37.230"E	50°19'0.980"N	497176.5318	5573871.137
11	104°57'22.890"E	50°19'2.000"N	496892.9575	5573902.799
12	104°57'14.970"E	50°19'0.560"N	496736.3024	5573858.417
13	104°57'6.050"E	50°18'56.170"N	496559.8091	5573722.938
14	104°57'6.050"E	50°19'26.960"N	496560.4263	5574673.928
15	104°57'28.480"E	50°19'26.960"N	497003.9424	5574673.658
Нийт			175.74 га	

Сэлэнгэ аймгийн Түшиг суманд хэрэгжиж буй “Улаан-Овоогийн нүүсний ордыг ашиглах” төслийн MV-022059 лицензийн дугаар бүхий 175,75 га талбайг харууллаа.

Зураг 2. Төслийн талбайн байршил



**“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024**

1.2. Улаан-овоо нүүрсний уурхайн үйл ажиллагаа

Төслийн зорилго

Уг төслийн зорилго нь Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар олборлон ойролцоо төв суурин газрын хэрэглэгчид, дулааны цахилгаан станцуудад нийлүүлэхийн зэрэгцээ ОХУ, Хятад зэрэг орнуудад экспортлох зорилготой.

Төслийн хүчин чадал

“Юу Жи Эл Интерпрайзис” ХХК нь Улаан-Овоогийн ордыг ашиглах төслийн ТЭЗҮ-д тус ордыг 500-1000 тн нүүрс олборлох хүчин чадалтай байхаар төлөвлөн боловсруулсан байна. Уурхайн ашиглалтын нийт хугацаа 22 жил байна.

Уурхайн ажиллах горим

Уулын ажил нь 2 ээлжээр ажиллах бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Нүүрс олборлолт 518.71 мян.тн, хөрс хуулалт 615.0 мян.м³, хөрс хуулалтын дундаж коэффициент 1.19м³/тн байна.

Хүснэгт 2. 2024 оны нүүрс олборлолтын төлөвлөгөө

Үзүүлэлт	Нийт	2024 он											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нүүрс олборлолт, тн	518.7	30.7	30.0	30.0	40.0	40.0	40.0	45.0	51.0	51.0	51.0	55.0	55.0
Хөрс хуулалт, м ³	615.0	615.0	49.5	49.5	49.5	49.5	52.5	52.5	52.5	52.5	52.5	52.5	52.5

Уурхайн захиргаа аж ахуйн болон онцлох мэргэжилтэн зэрэг ажилтнуудаас бусад бүх ажиллагчдын хувьд ээлж зохион байгуулалт нь өдөр шөнийн хоёр ээлжээр гурван бригад ажиллах ба 21 хоног ажиллаад 7 хоногийн цалинтай амралттай байна. Харин ээлжээ дуусгаад дараагийн ээлжид гарах хооронд 24 цаг уурхай дээр амарна. Нүүрсний олборлолтыг ил аргаар явуулах бөгөөд хөрс хуулалт, тээвэрлэлт, олборлолтод ашиглах үндсэн техник нь экскаватор, бульдозер, автосамосвал, өрмийн машин зэрэг байна.

Уурхайн хил хязгаар, үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Ашиглах талбайн сонголтыг ордын зүүн хойд хэсэгт одоо ашиглаж байгаа бага хэмжээний олборлолт явуулж буй хэсгээс эхлэн уулын ажлыг цаашид үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Уулын ажлын чиглэл нь баруун, баруун хойшоо чиглэлд байна.

Уурхайн ашиглалтын хилийн байдал нь давхаргынхаа гаршийн дагуу тойрог үүсгэсэн мэтээр харагддаг. Нүүрсний давхарга нь гарш хэсгээрээ газрын хөрсөнд ойрхон ба брахиосинклинал байрлалтай байна.

2024 онд олборлох нүүрсний хэмжээ 518.71 мян.тн, хуулах хөрс 615 мян.м³ байна гэж төлөвлөгөөнд тусгалаа. Хөрс хуулалтын дундаж коэффициент 1.19 м³/тн. Улаан-Овоогийн нүүрсний ордын нөөцийн тооцооны хүснэгтийг хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Улаан-Овоогийн нүүрсний ордын нөөцийн тооцоо /2024.01.01-ний байдлаар/

Нүүрсний давхаргын дугаар	Анхны нөөц, /мян.тн/	Олборлосон нөөц /мян.тн/	Үлдэгдэл нөөц /мян.тн/ /2024.01.01/
Нийт А	19179.18	405.57	18773.61
Нийт В	14489.32	514.29	13975.03
НИЙТ С	15277.02	18.90	15258.12

**“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024**

	НИЙТ	48945.52	938.76	48006.76
--	-------------	-----------------	---------------	-----------------

Ухаж ачих ажил:

2024 онд нүүрсний борлуулалтын хэмжээнээс хамааран нүүрс олборлолт болон хөрс хуулалтын ажилд CAT-390F, PC-800, DX-800 экскаваторууд болон SANY SKT90S маркийн автосамосвалын хослолоор нүүрс олборлолт болон хөрс хуулалтад тус тус ажиллана. 2024 онд 518.71 мян. тн нүүрс, 615.0 мян. м3 хөрс, нийт 1,133.71 мян. м3 уулын цул ухаж ачих юм. 2024 онд экскаваторын ажлын цагийг зохицуулан хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажилд шилжүүлэн ажиллуулах боломжтой юм. Экскаватор ажлын цагийн 55 хувь нь хөрс хуулалт, 45 хувь нь нүүрс олборлолтод зарцуулагдана. Экскаваторууд 2024 онд нийт 6.480 мот. цаг ажиллана.

Уурхайн дотоод тээвэр

Дотоод тээврийн ажлын нэгдсэн үзүүлэлтийг Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. Дотоод тээврийн ажлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлтүүд	Тэмдэг	Хэмжих нэгж	Хөрс	Нүүрс	Хөрс
Автосамосвал						
1	Марк	SANY SKT90S				
1.1	Тэвшний багтаамж	E	м ³	35	35	35
1.2	Даац	Q _{тн}	Тн	60	60	60
1.3	Хурд	R _а	Км/цаг	50	50	50
Ажлын тооцооны үзүүлэлт						
2	Уурхайн жилийн хүчин чадал	A _ж	Мян. м ³			
3	Тээвэрлэлтийн зай нэг талдаа	L	М	1500	1100	1380
4	Автосамосвалыг ачаалах хугацаа	t _а	Сек	147	233	176
5	Автосамосвалын хөдөлгөөний хугацаа	t _{хө}	Сек	270	198	270
6	Автосамосвалын мөчлөгийн хугацаа	t _{эм}	Сек	777	719	806
7	Автосамосвалын цагийн бүтээл	Q _{ац}	м ³ /цаг	70	68	67.5
8	Автосамосвалын ээлжийн бүтээл	Q _{ээ}	м ³ /ээлж	700	680	675
9	Автосамосвалын хоногийн бүтээл	Q _{ах}	м ³ /хон	1400	1360	1350
10	Автосамосвалын сарын бүтээл	Q _{аж}	Мян. м ³ /с	39.2	38.1	37.8
11	Ээлж солилцох хугацаа	t _{эс}	Цаг	0.5	0.5	0.5
12	Парк дахь автосамосвалын тоо	N _{ап}	Ш	4	4	4
13	Нийт автосамосвалын жилд ажиллах цаг	t _{цаг}	Мот.цаг	25920	25920	25920
14	Нэг автосамосвалын жилд ажиллах цаг	t _{цаг}	Мот.цаг	6480	6480	6480

Уурхайн гадаад тээвэр:

Улаан – Овоогийн нүүрсний уурхай нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун тийш 7км, төмөр замын Шаамар өртөөнөөс баруун тийш 120км, Зэлтэрийн хилийн боомтоос баруун өмнө зүгт 17км-т оршино.

Сард 80,000 - 100,000 тн нүүрсийг Сүхбаатар өртөө рүү тээвэрлэнэ. Сүхбаатар хот хүртэл 135 км тээвэрлэнэ. Үүний 65 км нь сайжруулсан зам, 70 км нь засмал зам байна. Автосамосвал нь өдөрт 1-2 рейс хийнэ. Гадаад тээвэрт ачигдаж байгаа нүүрсийг уурхайн автопүүгээр жинлэнэ. Гадаад тээврийг өөрийн тээврээр гүйцэтгэнэ.

Нүүрсний агуулахаас дугуйт ачигчаар гадаад тээврийн машинд ачина. Энэхүү төсөлд CAT-980 маркийн маркийн дугуйт ачигчаар 100 тн-ийн даацтай автосамосвалд ачна.


Улаан-Овоогийн нүүрсний уурхайгаас Цагааннуур сум, Шаамар өртөө, Сүхбаатар боомт гэсэн маршрутаар нийтдээ 130 км хатуу хучилттай замаар 100тн даацтай автосамосвалаар тээвэрлэнэ. Энэхүү тээврийн ажлыг гэрээт аж ахуйн нэгжүүд гүйцэтгэнэ.

1.3. Машин механизм, тоног төхөөрөмж

Хүнд машин механизмын засварын цех

Уурхайн засвар техникийн үйлчлэгээний барилга байгууламжууд болон агуулахын аж ахуйн байгууламжуудыг уурхайн карьерын дэргэд байгуулна. Уг байгууламжийн сендвичэн хавтангаар барилгын туслан гүйцэтгэгч байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нийт 651м² талбай бүхий засварын газрын барилга байгуулахаар тусгасан.

Зураг 3. Засвар техник үйлчилгээний барилга байгууламж



Тайлбар:

1. Хүнд даацын автосамосвалын засвар үйлчилгээний хэсэг
2. Хөнгөн тэрэг засвар үйлчилгээний хэсэг
3. Эд анги сэлбэг хэрэгслийн агуулах
4. Багаж хэрэгслийн хадгалах өрөө
5. Хийн болон цахилгаан найруулгын өрөө
6. Засварын газрын контор болон хувцас солих өрөө

Тоног төхөөрөмж

Хөрс хуулалт:

Уурхайн хүчин чадлыг экскаваторын бүтээл, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн хүрэлцээ хоршин ажиллах боломжтой нөхцөлөөр экскаваторын бүтээлийг бүрэн ашиглах боломжийг харгалзан 8.1 м³ шанаганы багтаамжтай САТ-6015 маркийн экскаваторыг сонгон ажиллаж байна.

Нүүрс олборлолт:

Нүүрс олборлолтын ажилд уурхайн хүчин чадлаас хамааруулан 2.4м³ шанаганы багтаамжтай САТ-336GS экскаваторыг сонгон авсан.

Уурхайн туслах техникийн сонголт

Ил уурхайн туслах тоног төхөөрөмжөөр уурхайн дотоод тээврийн зам цэвэрлэхэд САТ 14М загварын автогрейдер ажиллана. Экскаваторын талбайн ул цэвэрлэх, тэслэгдсэн блокийн нурлыг түрж шуух, ашиглалтын доголдуудад зам гаргах зэрэг туслах ажлуудыг САТ D8 загварын бульдозероор гүйцэтгэнэ. Ус болон түлшний автоцистерн бусад тоног төхөөрөмж болох кран, бага оврын автосамосвал зэргийг худалдан авч ашиглана.

1.4. Агуулахын аж ахуй

Уурхайн агуулахын аж ахуйн байгууламжуудыг дараах байдлаар жагсаав.

Хүснэгт 5. Уурхайн агуулахын аж ахуйн байгууламжууд

Тэсрэх материалын агуулах	Тэсрэх материалын агуулахыг уурхайн талбайгаас 5км зайд байх бөгөөд нэг сарын тэсрэх бодисын хэрэгцээг ханагх хэмжээтэй хагас далдалсан агуулах барьж байгуулна. Агуулах нь гэрэлтүүлгийг станцаар хангана. Агуулахыг тойруулан авулгүйн зайд хашаа барин байнгын харуул хамгаалалт гаргана. Хашаа далан нь байгууламжуудыг гаднаас харах нөхцлийг нь хаах хэмжээтэй өндөр байна.
Дизель түлшний агуулах	Дизель түлш хадгалах, том ба бага оврын машин механизмыг цэнэглэх байгууламжийг үйлдвэрлэлийн хэсэгт байрлуулна. Дизель түлшний агуулах нь тус бүрдээ 100тн-ын багтаамжтай хоёр ёмкость байна. Ёмкость,насосыг бетоно хашаагаар тойруулан хамгаална. Мөн түлш тээвэрлэх цэнэглэх түлшний машин ажиллуулна.
Материалын агуулах	Засварын газрын зүүн талд залгаад агуулахын байр байрлана. Цахилгаанаар ажилладаг гүйдэг хаалга өмнө талд нь байна. Агуулах нь бараа материал хураах тавцангуудтай, сэрээт ачигчтай байна. Агуулахын барилгын зэргэлдээ задгай, гадуураа хашаатай бараа хадгалах талбай байрлана.
Тосолгооны материал хадгалах, түгээх байгууламж	Тос, тосолгооны материал болон хөргөлтийн шингэн хадгалах, тэдгээрийг засварын цех рүү түгээх байгууламжтай байна. Моторын тос, гидрийн шингэн, дифференциалын тос, трансмиссийн тос, хаягдал тос, хөргөлтийн шингэн, хаягдал хөргөлтийн шингэнийг хэвтээ савнуудад хадгална. Тос, тосолгооны материал, насосыг бетонон хашаагаар тойруулж хамгаална.

Бусад барилга, байгууламжууд

Зам харилцаа

Шаамар-Цагааннуур болон Цагааннуур-Улаан-Овоогийн шороон замын даланг сэргээн засах, шаардлагатай хэсгүүдэд замыг өргөсгөх, гадаргыг нь хөрс барьцалдуулагчаар бэхжүүлж усны элэгдэл, тоосжилт үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд орон нутгийн зам харилцаа эрс сайжирсан. Түүнчлэн 3 модон гүүрийг төмөр бетонон гүүрээр сольсон. Цаашид замын эвдрэлийг байнга засаж сайжруулна.

Цахилгаан хангамж

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Улаан-Овоо нүүрсний уурхайн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 35/10 кВ-ын Цагааннуурын дэд станцын 10 кВ-ын хуяаргилах байгууламжийн 10 кВ-ын Зэлтэр агаарын шугамын тулгуур №507-аас салбарлуулан 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар уурайн хэрэгжлэгчид нь цахилгаан эрчим хүчээр хангагдхаар 2021 оны 6-р сарын 30-ны өдрийн 01/187-2021-06 тоот Техникийн нөхцөлийг ДСЦТС Хк-аар гаргуулж, уг техникийн нөхцлийн дагуу 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам болон “Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 35/10 кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг”-уудыг “Смарт Электрик Интерженеринг” ХХК-аар гүйэтгүүлж холбогдох байгууллаагадаар батлуулсан.

Хог хаягдал

Улаан-овоо нүүрсний уурхайн үйл ажиллагааны үр дүнд үүсэж буй хог хаягдлын байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах зорилготойгоор ажилладаг бөгөөд ажилчдын хотхон, бусад хэсгүүдээс гарсан хаягдлыг муутгаж, орчны газрын хөрсийг бохирдуулахгүйн тулд хог хаягдлын түр цэгт ангилан хаях, энэ талаар зохих мэдлэгийг ажиллагсдадаа эзэмшүүлж, зааварчилгаа өгч ажиллана.

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

Төслийн үйл ажиллагааны явцад төсөл хэрэгжүүлэгч нь аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ялган ангилж савлаж хаях, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор цуглуулах, хадгалах, ачуулах, тээвэрлэх, устгах зарчмыг баримтлан хог хаягдлыг зүй зохистой удирдан зохицуулахыг зорин ажиллах болно.

Аюултай хог хаягдал

Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална. Аюултай хог хаягдлыг хадгалах сав нь стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна. Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална. Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэнэ.

Хатуу хог хаягдал

Уурхайд дахин ашиглах болон дахин боловсруулах хог хаягдлын үр дүнтэй зохицуулалт хийхдээ хог хаягдлыг ангилан цуглуулах зориулалтын сав байрлуулж цуглуулан авах, хогийн савны хэмжээг хог хаягдлын үүсэх байдалтай уялдуулан хийх нь зүйтэй бөгөөд ажлын байрнаас үүсэх хог хаягдлын бүрдлээс хамаарч оффис болон бусад газруудад тавих хогийн савнуудыг өөр өөр байлгана.

Хог хаягдлыг хадгалах талбай

Аюултай хог хаягдлыг устгах, дахин боловсруулах, дахин ашиглах тохиромжтой арга зүй, тодорхой болох хүртэл хаягдлын удирдлагын төв дээрх аюултай хаягдлыг хадгалах талбай дээр аюулгүйгээр хадгалж байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Уур амьсгал

Төслийн талбай нь эрс тэс уур амьсгалтай. Хур тунадасны хэмжээ жилд 100-150 мм хүрэх ба үүний 60-70% нь зуны 6-8 дугаар саруудад ордог. Жилийн хамгийн өндөр агаарын температур нь 6-7 дугаар саруудад 35-40 С хүрдэг бол өвлийн хамгийн бага температур нь 12-1 дүгээр саруудад 35-40 С хүрнэ. Цасны дундаж зузаан нь 10-20см хунгарласан хэсэгтээ хамгийн ихдээ 2м хүрнэ. Салхи нь ихэвчлэн баруун хойд болон зүүн хойд чиглэлээс дундаж 7м/сек хурдтай салхилна.

- Жилийн дундаж салхины хурд 2-5м/с
- 1 дүгээр сарын дундаж температур -28.5
- 7 дугаар сарын дундаж температур +19.20С
- Жилийн хур тунадасны нийлбэр 235мм

2.2. Газар зүйн тогтоц

Улаан-Овоогийн нүүрсний орд нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун тийш 7 км зайд орших бөгөөд Зэлтэр голын хөндий нь хойд болон өмнөд талаасаа Жид, Бүтээлийн нурууны салбар уулсаар хүрээлэгдсэн бөгөөд уул нь 40-60км-ийн өргөнтэйгөөр 100км орчим урт үргэлжилнэ. Уул нуруу нь зүүн хойд чиглэлд сунаж тогтсон бөгөөд Зэлтэр гол болон Сэлэнгэ мөрний голын системийн усны хагалбар юм. Ордын орчмын уулс нь Зэлтэрийн голд цутгадаг жижиг горхинуудын гольдирулуудаар хөндлөн хэрчигдсэн бөгөөд хэд хэдэн жижиг горхи ордын талбайг дайран Зэлтэрийн голд цутгадаг. Улаан-Овоогийн нүүрсний орд нь Рихтерийн шаталбараар 8 хүртэл баллын газар хөдлөлийн бүсэд оршиж байна. Сэлэнгэ аймгийн Түшиг сум нь физик газар зүйн хувьд Хангайн нурууны салбар бүтээлийн нурууны салбар бүхий ойт

хээрийн бүсэд багтдаг. Сумын нутаг дэвсгэр нь ой модоор хүрээлэгдсэн мал аж ахуйн болон газар тариалан голлон эрхэлдэг. Нийт 249282 га нутаг дэвсгэртэй.

2.3. Геологийн тогтоц

Улаан-Овоогийн чулуун нүүрсний орд дунд-дээд юрагийн настай Зэлтэрийн хотгорт оршино. Зэлтэрийн хотгор нь 80-аад км сунаж тогтсон, хэд хэдэн жижиг хотгоруудаас бүрэлдэн тогтдог уулс хоорондох томоохон геологийн структур юм. Тухайлбал, Гурмансангийн, Хундаа голын, Улаан-Овоогийн, Түшигийн, Хуширийн гэсэн хотгоруудаас бүрэлдэн тогтох бөгөөд тэдгээр нь хоорондоо доод палеозойн хувирмал занар болон дээд пермийн галт уулын /вулканоген/ чулуулгуудын өргөгдлөөр зааглагдана.

Тэдгээрийн нэг болох Улаан-Овоогийн хотгор нь зүүн-хойт чиглэлд сунаж тогтсон байна. Тус хотгорын өргөн нь 5-6 км, уртаашаа 12 км юм. Улаан-Овоогийн нүүрсний ордын геологийн зургийг доорх зурагт үзүүлэв.

Үүнээс үзэхэд районы геологийн тогтоцод дунд кембрийн доод ордовикийн ангилагдаагүй ногоовтор өнгийн хувирмал занар ба занаржсан нормаль-тунамал чулуулаг, доод пермийн галт уулын хурдас болон дунд-дээд юрагийн настай нүүрс агуулагч терриген хурдасууд оролцох байна. Тухайн районд дараах төрлийн давхарга зүйг ялгаж болно. Үүнд:

- Доод палеозойн хурдас /Pz1/
- Доод перм /P1 hn/
- Юрагийн тогтолцоо /J2-3 chg/
- Дөрөвдөгчийн тогтолцоо /QIII-IV; QIV/

Юрагийн тогтолцооны хурдас тухайн ордын хүрээнд нэлээд тархсан. Юрагийн тогтолцоо нь эх газрын гаралтай нүүрс агуулагч терриген тунамлаас тогтох бөгөөд түүний литологид гүфелсэн чулуу, гүф, хөрзөн чулуу, элсэн чулуу, гравелит, аргиллит, нүүрсүүд давамгайлах ба бага хэмжээгээр хорзон чулуу, алевролитууд оролцоно.

Зүсэлтийн бүтэц, литологийн найрлагаараа Шарын голын свит нь дотроо гурван дэд свитэд ялгагдана. Үүнд доод, дунд ба дээд дэд свитүүд болно. Эдгээрээс нүүрс агуулагч нь дунд дэд свит юм. Тэр нь цайвар саарал полиминтийн элсэн чулуу, алевролит ба нүүрсний давхаргаас бүрэлдэн тогтоно.

Зүсэлтийн дээд хэсэгт нэлээд зузаан чулуун нүүрсний давхарга байрлана. Энэ давхаргын шаталтын ул мөр /выгорание/ ордын хойд хэсэгт Улаан-Овоогийн толгод орчмоор нэлээд тархсан байна. Энд хайгуулын шугам IY ба XIII-ын хооронд шатсан чулуулгийн зузаан 10- аас 42 м-ийн хооронд хэлбэлзэх ба термаль өөрчлөлтийн улмаас улаан тоосгоны өнгөтэй болжээ. Зүсэлтийн доод хэсэгт 9-11 нүүрсний үе ба үенцрүүд 0,9-ээс 2,0 м-ийн зузаантай тааралдана. Дунд дэд свитийн зүсэлтийн нийт зузаан нь 185 м орчим байна. Дээд дэд свит /J2-3 chg3/ нь гол төлөв бараан-саарал өнгөтэй, нягт нэг төрлийн аргиллитээс тогтоно.

Зүсэлтийн баруун чиглэлд эхлээд алевролит ба элсэн чулууны үенцрүүд илрэх ба цаашид зүсэлтийн доод хэсгүүдэд хүрэн саарал өнгийн жижиг ба дунд ширхэгтэй элсэн чулуунаас бүрэлдэн тогтоно. Дээд дэд свитийн зузаан нь 140 м. Нийт Шарын голын свитийн хурдасны зузаан 520 м юм.

Тухайн районд дөрөвдөгчийн хурдас Зэлтэр голын ба түүний цутгал голуудын хөндийг дүүргэн байрлахаас гадна уулсын орой болон хажуу хэсгийг хучиж тогтоно. Энэ хурдаснуудыг насаар нь ойролцоогоор орчин үеийн /QIV ба дээд дөрөвдөгч-орчин үеийн /QIII-IV/ гэж ялгаж үзэж болно. Түүний зузаан харилцан адилгүй бөгөөд 3-4 м-ээс 17 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

2.4. Гадаргын усан сүлжээ

Улаан-Овоогийн нүүрсний ордын район нь гадаргын усны сүлжээгээр элбэг бөгөөд ордын нүүрсний үе давхарга нь Зэлтэрийн голын хөндий болон голын хойд талд байрлалтай байна.

Зэлтэр голын сав газар Монгол орны хойд хил орчимд баруун өмнөөс зүүн хойш чиглэлд сунаж тогтжээ. Сав газрын эх нь Зэдийн нуруунаас өмнө тийш үргэлжлэх Оросын нуруу, Өнгөлөг нуруу, Балинтайн нуруу, тэдгээрийн салбар уулсаар хүрээлэгдэн орших ба сав газрын хойт талаар Зэдийн нуруу, зүүн өмнө талаар Бүтээлийн нуруу хүрээлэн байрлажээ. Сав газрын өмнө талаар Ангархай нуруу Хангайн даваа үргэлжлэн оршино. Энэ гол 4494.8 ам км талбайгаас усжих бөгөөд Зэд голын баруун гар талын цуггал болно. Голын урт 175 орчим км урт байна. Зэлтэр голын эх нь 1740 м өндрөөс эх аван зүүн урагш чиглэн урсах Азаргын гол болох ба энэ гол Могойт голтой нийлсний дараа Зэлтэр хэмээн нэрлэгдэнэ. Азаргын голын эхэнд зүүн гар талаас Зүүн буурал булаг, Могойт голын эхэнд мөн зүүн гар талаас Өлөнт булаг тус тус тэдгээрт цутгана.

2.5. Гидрогеологийн нөхцөл

Ордын районд 1992-1995 онуудад явуулсан гидрогеологийн судалгаагаар 8 төрлийн гидрогеологийн давхарга зүйг ялгажээ. Үүнд:

1. Дөрөвдөгчийн аллювийн хурдасны уст үе
2. Нүүрсний дээд хэсгийн аргиллитийн уст үе
3. Нүүрсний давхаргын уст үе
4. Нүүрсний доод талын элсэн чулууны уст үе
5. Элсэн чулууны уст үе
6. Туфэлсэн чулууны уст үе
7. Туф хөрзөн чулууны уст үе
8. Андезит-базальтийн уст үе

Мөн зүүн тектоник хагарлын бүсийн уст бүрдэл. Үүнээс аргиллитийн өгөршлийн бүсийн уст үе хязгаарлагдмал тархалттай юм. Нүүрсний ордын карьерын усжилтад нөлөөлөх уст үеүд хоорондоо гидравлик холбоотой тул суурь чулуулгийн үндсэн нэг уст цогцолборт хамаарах бөгөөд доорх гидрогеологийн параметруудтэй байна. Үүнд:

- Зузаан 300 м
- Шүүрэлтийн коэффициент 10,25 м/хоног
- Ус дамжуулах коэффициент 1540 м²/хоног
- Түвшин дамжуулалтын коэффициент 4,4*10⁴м²/хоног
- Ус өгөмж 0,035 /3,5%/

2.6. Хөрсөн бүрхэвч

Монгол орны хөрс-газар зүйн мужлалаар Хангайн их муж, уулын тайгын ширэгт чандруувтар хөрсний бүслүүр, Хөвсгөлийн муж, Хөвсгөлийн зүүн хэсгийн районд хамаарагдана.

Монгол орны хөрс газарзүйн (Доржготов, Максимович, 1984) мужлалаар тус район нь хөрс био-уур амьсгалын Төв Азийн их мужийн Хангайн мужийн Зүүн Хөвсгөл, Сэлэнгийн тойрогт хамаарагдана. Сэлэнгийн тойргийн бэсрэг уулын ард цэвдэгт-тайгын, ширэгт-тайгын гүн цэвдэгт, ой-нугын улирлын цэвдэгт хөрс, нугажуу хар шороон ба хар хүрэн хөрс тархдаг. Уул хоорондын өргөн хөндийд, нугын хар шороон ба хүрэн хөрстэй. Сэлэнгийн хөндийд үе үе тохиолдох нарсан ой ширэгт-сул чандруулаг элсэн хөрстэй.

2.7. Газар эдэлбэрийн байдал

Улаан-Овоогийн нүүрсний орд газар нь ОХУ, Монголын хилээс 7,0 км зайд байрлах тул улсын хилийн зурвас газарт хамаарагдана. Ордын орчмын газар нутагт цөөн тооны малчин иргэд мал аж ахуй эрхлэн суурьшдаг тул тус газар нутаг нь одоогийн байдлаар бэлчээрийн зориулалтаар

ашиглагдаж байна. Улаан-Овоогийн ордоос урагш Зэлтэрийн голын урд талын хөндийд бага хэмжээний талбайд нутгийн иргэд газар тариалан эрхэлж байна. Тариалангийн талбайг усаар хангахын тулд Зэлтэрийн голоос суваг татаж гар аргаар усалгаа явуулдаг.

2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг

Улаан-Овоогийн орд нь тусгай хамгаалалттай газар нутагт хамаарагдахгүй. “Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь Монгол улсын “Хилийн тухай хуулийн 27-р зүйлд заасан Улсын хилийн зурвас газарт мөрдөх журам, хориглох зүйлийг нарийн чанд баримтлан, хил хамгаалах байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлж ажилладаг.

2.9. Ургамалжилтын төлөв байдал

Ургамлан бүлгэмдлийн өөрчлөгдөл ба сэргэн ургалтын анхан шатны материалуудыг статистик аргаар боловсруулав (Василевич, 1969). Өвслөг ургамлын амьдралын хэлбэрийн ангилаг И.Г.Серебряков (1962, 1964), Д.Баясгалан (1985, 1992) нарынхаар хийсэн. Ургамлын экологи-ценозын бүлгийн ангилаг Т.Н.Буторина (1967) ба С.А.Ильинский (1963) нарын боловсруулсан ангиллаар дөрвөн бүлэгт ялгасан.

1. Өндөр уулын ургамал – таг, царамд ургадаг криофит, психрофит, мезопсихрофитууд;
2. Тайгын ургамал - чийг хангалттай газар ургадаг, сүүдэрт тэсвэртэй мезофитууд;
3. Ойн нугын ургамал - дунд зэргийн чийгтэй газар ургадаг ойн болон нугын мезофит зүйлүүд;
4. Хээр ба ойт хээрийн ургамал - дутмаг юм уу түр зуур дутмаг чийгтэй нөхцөлд ургадаг, гэрэлд дуртай ксерофит ба мезоксерофитууд тус тус орно. Энэ газар нутгийн ургамлын аймагт Дорнод Сибирийн, түүний дотор Дагуурын тайгын ба өндөр уулын ургамалжилтын төлөөлөгчид голлох байрыг эзэлнэ.

2.10. Амьтны аймаг

Энэ бүс нутгийн амьтны аймгийн үндсэн төлөөлөгч болох шувуу хөхтний бүрэлдэхүүн нь үндсэндээ ойн, өөрөөр хэлбэл Евро-Азийн шилмүүст тайгын зүйлүүд зонхилсон манай орны бусад уулархаг нутагтай харьцуулахад экологийн хувьд нэгэн жигд, цөөвтөр зүйлийн бүрэлдэхүүнтэй, тэгэхдээ тоо толгойн хувьд баян нутаг.

Энэ бүс нутагт одоо мэдэгдээд байгаагаар манай орны хөхтний зүйлийн 26.8%-тай тэнцэх 37 зүйл хөхтөн нутагладаг.

Амьтны аймгийн ховор ховордсон зүйлийг хамгаалах чиглэлийн үүднээс авч үзвэл энэ нутаг шувуу, хөхтнөөр олон улс, Монголын анхаарал татсан устаж байгаа юм уу онцгой ховор зүйл цөөнтэй. Манай орны бусад зарим бүс нутагтай харьцуулахад шувуу хөхтөн нь одоохондоо онц их хөндөгдөөгүй нутаг гэж үзэж болно.

3. ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Байгалийн орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөлөл

Энэхүү төслийн үйл ажиллагааны явцад газрын гадарга ,хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөг шууд эвдрэлд орохоос гадна усны нөөцийн хомсдол үүсэж, агаарын бохирдол ойр орчмын талбайд тархаж амьтны аймаг, ургамалан нөмрөг, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх замаар шууд бус нөлөөлнө.

Уурхайн ашиглалтын хугацаанд хэд хэдэн төрлийн хуримтлагдах нөлөөлөл тодорхойлогдсон байна. Үүнд:

- Ахуйн болон техникийн гаралтай хог хаягдлын хэмжээ өсөх
- Ил уурхайн болон гадаад дотоод овоолгын гадаргуугаас тоос хийсэх, агаар дахь бохирдуулагч агууламж өсөх

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

- Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд өөрчлөгдөх, хөрсний зарим нэг хүнд металлуудын агууламж нэмэгдэнэ. Зарим тохиолдолд хүлцэх хэмжээнд хүрэх, бохирдуулагч эх үүсвэрүүдийн орчимд хүлцэх хэмжээнээс хэтрэх, хөрсний урвалын орчин өөрчдөгдөх зэрэг үзэгдлүүд илэрч үйл ажиллагааны явцад бохирдуулагч бодисууд хуримтлагдах
- Агаарын бохирдол зөөгдөх, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөгийн байгалийн өөрөө нөхөн сэргэх чадвар буурах, устгах замаар байгаль орчны эргэн сэргэхгүй доройтолд хүргэх
- Бохирдсон хөрсний угаагдлаар химийн бохирдол гадаргын усыг бохирдуулах зэрэг хуримтлагдаж нөлөөллийн цар хүрээ тэлж болзошгүй.

Иймд дээр дурдсан нөхцөлүүдийг харгалзан уурхайн ашиглалтын талбай орчимд агаарын бохирдол, газрын гадарга, хэвлий болон хөрсний эвдрэлд, ургамлан нөмрөгийн талхагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, усны нөөцийг хамгаалах, хэмнэлттэй хэрэглэх, байгаль орчны нөхөн сэргээлтэд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

3.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл

- Уурхайн гадаад болон дотоод тээврийн замаас тээвэрлэлтийн явцад тоосжилт үүсэх, тоос босох
- Ухаш овоолгоос салхиар тоос дэгдэх (Агаарт дэгдэж буй тоос)
- Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас хийн бохирдуулагч
- Яндангаас үүсэх утаа
- Дуу шуугиан
- Үнэр

Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг. Түлшний найрлагад агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч, дэгдэмхий органик нэгдлүүдээс гатлаагаар агаарт хүхрийн ислүүд, нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд, метан болон метан агуулаагүй ууршимтгай органик, нэгдлүүд болон давхар азотын ислүүд ялгардаг.

3.3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хөрс, газрын гадарга, хэвлийд дараах нөлөөллүүдийг үзүүлж болзошгүй. Үүнд:

- Уурхайн олборлолтын явцад өнгөн хөрс хуулах үед өнгөн хөрсний үржил шимт, морфологи тогтоц алдагдах, хөрс нягтарших
- Төслийн талбайд ухаш буюу онгорхой нүх, овоолго үүсч, тухайн орчны унаган төрх өөрчлөгдөх
- Дотоод, гадаад тээвэрлэлтийн авто зам үүсч, газрын гадарга өөрчлөгдөх
- Уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа хэсэгт хөрсний элэгдэл эвдрэл үүсэх
- Хөрсний шимт бодисын нөөц хомсдох, хөрсний бохирдол, элэгдэл нэмэгдэх
- Хөрсний биологийн бүтэц ба шинж чанар өөрчлөгдөх
- Ухсан газарт ландшафтын эвдрэл үүсч, хөрсний генетик үе давхаргууд холилдон морфологи тогтоц бүр мөсөн алдагдах
- Ордын чулуулаг хөрс эвдрэлд орж байгалийн тогтолцоо алдагдах
- Газрын гадарга болон нүүрсний давхаргад ан цав гарснаар нүүрсний өөрөө шаталт үүсэх эх үүсвэр бий болох
- Газрын гадарга эвдрэлд орж суулт үүсэхээс гадна гулсах, нурах, цөмрөх аюултай
- Догол мөргөцгүүдэд нуралт үүсэх
- Бороо болон үерийн ус урсаж гуу, жалга үүсч газрын гадаргыг эвдрэлд оруулах
- Ургамлан нөмрөгийг хуулснаар гадаргын чулуулаг өгөршиж эвдрэлд оруулах

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

- Газрын хэвлий дэх ашигт малтмал болон шавар, чулуу гэх мэт бусад дагалдах ашигт малтмалын нөөц хомсдох
- Хог хаягдлаас үүссэн бохирдол

3.4. Усан орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн талбайн ашиглалтаас усан орчинд дараах байдлаар нөлөөлж болзошгүй. Үүнд:

- Уурхайн шүүрлээр гүний усны нөөцөд нөлөөлөх
- Биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгааны үед усны нөөц ихээр ашиглах
- Зам талбайн тоосжилт дарах зорилгоор гүний усны нөөцөд нөлөөлөх
- Ахуйн хаягдал бохир ус, шатах, тослох материалын зохисгүй хадгалалт, тээвэрлэлт, зайлуулалтаас үүдэлтэйгээр усан орчин бохирдож болзошгүй

3.5. Ургамалан нөмрөгт үзүүлж болзошгүй нөлөөлөл

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас ургамалан нөмрөгт дараах сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй. Үүнд:

- Уурхайн ашиглалтын улмаас ойролцоох газрын ургамалан нөмрөг тоосонд дарагдах
- Машин техникийн нөлөөгөөр газрын гадарга талхлагдах, ургамалан нөмрөг доройтох
- Бэлчээрийн ургамал ба ургамлын аймгийн байгалийн төрх алдагдах, төрөл зүйл багасах
- Ургамалан нөмрөг тоосонд дарагдсанаар фотосинтезийн процесс алдагдах, ургамал ургах чадвараа алдах
- Ургамлын зүйлийн бүрдэл багасах
- Төслийн үндсэн үйл ажиллагааны улмаас ургамалан нөмрөг дарагдах, арчигдах
- Авто машины хөдөлгөөн, газар шорооны ажлын явцад салхитай үед шороо тоос босох, тоос шорооны хуримтлал нь тухайн хэсгийн ургамалжилт дээр унах

3.6. Амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны үед амьтдын амьдрах орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

- Амьдрах орчны доройтол: Карьер ухаж хонхор үүсэх, машин холхисоор олон салаа зам бий болж амьдрах орчин доройтох
- Уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлоход амьтдын амьдрах орчинг бүр мөсөн алдагдуулах
- Уурхайн олборлолтын ажил явагдсанаар зэрлэг амьтад чөлөөтэй нүүдэллэж чадахаа больж нэг талдаа бөөгнөрөх, гэрийн малтай ус бэлчээр булаацалдах
- Хөдөлгөөний эрчим нэмэгдэж, машин техникийн дуу чимээ ихсэх
- Хөрс хуулалтаар шавж, мэрэгчдийн амьдрах, бойжих орчин алдагдах, үүр нүх оромж сүйдэх
- Хот суурин, кемп, дэд бүтэц байгуулагдсанаар амьдрах орчин алдагдах, ажилчдын хотхон бий болж хог овоорох, тодорхой талбай талхлагдах
- Нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд уурхайн ерөнхий үйл ажиллагаа ачаа тээвэрлэлт, дуут дохио нөлөөлөх
- Уурхайн талбайг хашаажуулаагүйн улмаас уурхайн ухсан нүхэнд мал, амьтан үхэж үрэгдэх

3.7. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн талбай нь гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн зааг, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хил заагтай давхцалгүй байна.

3.8. Түүх соёлын өвд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн талбайд түүх дурсгалын зүйлс болон археологи, палеонтологийн олдвор илэрсэн бөгөөд төслийн талбайд илэрсэн олдворуудад мэргэжилийн байгууллагад хандаж нарийн зөвлөгөө мэдээллийг авна.

Шаардлагатай тохиолдолд илэрсэн олдворуудад мэргэжлийн байгууллагын зүгээс хөрс хуулалт, олборлолтын явцад дээжлэлт хийлгэж, олдворын авран хамгаалалт арга хэмжээг авна.

Нийгэм-Эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийг хэрэгжүүлснээр орон нутаг, улсын эдийн засагт татвар нэмэгдэх, ажилчдын орлого нэмэгдэх зэргээр эергээр нөлөөлнө. Ажилчдын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг авч үзэн цалин хөлсийг цаг тухайд олгох, бүх нийтийн амралтын өдрүүдээр амраах зэрэг асуудлуудыг харгалзан үзэх шаардлагатай. Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм-эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Ажлын явцад хийсэн судалгаа, шинжилгээ, судлаачдын гаргасан үнэлгээ, дүгнэлтүүдийг үндэслэн төслийг хэрэгжүүлэхдээ орчиндоо үзүүлж болзошгүй болох гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах болон арилгахад дараах зөвлөмж, арга хэмжээ, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллах, цаг тухайд нь авч хэрэгжүүлэх нь нэн чухал.

4.1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

- “Үйл ажиллагааны хүрээ”-нд тусгагдсан төслийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн заалтууд, байгаль орчныг хамгаалах болон бусад холбогдох стандарт, норм, дүрэм, журмыг төслийн үйл ажиллагааны бүхий л хугацаанд мөрдөж ажиллах
- Төлөвлөгөөндөө байгаль хамгаалахад зориулсан зардлыг тусган, нарийвчилсан үнэлгээний тайланд төлөвлөж өгсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллах
- Газар шорооны ажлыг гүйцэтгэхдээ төслийн талбайгаас бусад газарт хүн мал, амьтан, машин техник унах ухлага малталт хийхгүй байх, хийсэн тохиолдолд эргэн булж нөхөн сэргээх ёстой
- Ажил эхлэхийн өмнө ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, гэнэтийн осол гамшгаас урьдчилан сэргийлэх яриа танилцуулга хийж, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны самбар байрлуулах, ажлын хувцсаар хангаж, галын хортой ажиллах заавар өгч, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх буланг байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байх ёстой

4.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх багасгахын тулд дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Үүнд:

- Хөрсний чулуулаг болон нүүрс тээвэрлэх үед уурхайн орчинд маш их тоос тархах тул авто замыг байнга услах, сул шороо, чулууг хусч зайлуулах
- Тоос шороог багасгахад услах болон тоос дарах зориулалтын уусмалыг ашиглах
- Техник, тоног төхөөрөмжийг тогтмол үзлэг оношилгоонд оруулах, засвар үйлчилгээг байнга хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх
- Экскаватор болон дугуйт ачигчаар хөрс, нүүрсний мөргөцгийг ухаж ачих үед ажлын талбай орчимд үүсэх тоосыг дарах, мөргөцгийг услах арга хэмжээ авах
- Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх, өгөршлийн бүсэд халалт үүссэн үед галын цэгийг даруй дарж унтраах

4.3. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх багасгахын тулд дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Үүнд:

- Ан цав гарсан хэсгийг шаварлаг хөрсөөр дарж агаар нэвтрэхээс хамгаалах
- Боломжтой нөхцөлд хөрсний чулуулаг дахь дагалдах ашигт малтмалыг ашиглах
- Тээвэрлэлтийн явцад машин, техникийн даацыг хэтрүүлэхгүй байх
- Маршрутын бус замаар тээвэрлэлт хийхгүй байх

4.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах

Төслийн хэрэгжилтийн улмаас тухайн орчны хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч нь доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Олборлолт, ашиглалтад өртөх газруудын өнгөн хөрсийг хуулахдаа үржил шимт хөрс болон түүний доод үеийн шимэрхэг хөрсийг тухайн хөрснүүдийн онцлогоос хамааруулан 10-20 см хүртэл зузаантай хуулах
- Хуулсан хөрсөө тусад нь овоолох ба нөхөн сэргээлтийн ажилд ашиглахад нөөцлөн хадгалах. Дээрх арга хэмжээг аваагүй тохиолдолд эвдэрч доройтсон газруудад биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардлагатай шимт хөрсний нөөцгүй болно
- Уул уурхайн олборлох үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрч доройтсон, ялангуяа хурдас чулуулгийн овоолгуудын огцом налуу хажууг сайтар хэлбэршүүлэн засч техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийсний дараа шимт хөрсөөр хучих
- Олон салаа зам гаргахгүй байхаас гадна ашиглалтад өртөхгүй талбайг эвдрэлд оруулахгүй байхад анхаарах
- Тээвэрлэлтийн замыг эмх цэгцтэй зохион байгуулж тогтсон маршрутаар явах.
- Нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ “Уул уурхайн улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” болон бусад холбогдох журам, заавар, стандарт зэргийг мөрдөж ажиллах
- Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр хучихын өмнө “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартын дагуу бохирдуулагч бодис, элементүүдийн агууламжийг тодорхойлуулж холбогдох арга хэмжээг авах, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг аль болох богино

хугацаанд шимт хөрсөөр хучиж ургамалжуулах, ингэснээр хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ.

- Хөрсөнд шатах, тослох материал болон бусад бодис асгарч алдагдсан тохиолдолд нэн даруй цэвэрлэх арга хэмжээг авах, шаардлагатай техник хэрэгслээр хангах.
- Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг төрөлжүүлэн ангилан ялгаж зориулалтын цэгт түр хадгалан шил, лааз, хуванцар эдлэл, төмрийн хаягдал зэргийг хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаах, хоол хүнсний хаягдлыг ариун цэвэр, эрүүл ахуйн стандартад нийцүүлэн ариутгал, устгал хийн зайлуулах зэрэг арга хэмжээ авах, хур хог үүсгэхгүй байх

4.5. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах

Төсөл хэрэгжүүлэгч нь усны нөөц, чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгахын тулд дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Үүнд:

- Усны боломжит нөөцийн дүгнэлт болон ус ашиглах дүгнэлт гаргуулж заасан хэмжээнээс давуулалгүй усыг зүй зохистой ашиглах
- Хаягдал усыг дахин ашиглах технологийн судалж үйлдвэрлэлд нэвтрүүлэх

Газрын доорх усны чанар өөрчлөлтөөс урьдчилан сэргийлж:

- Үйлдвэрлэлд хэрэглэх тэсэлгээний бодис, химийн бодисын агуулах сав баглаа боодол, байрны бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж байх
- Газрын доорх усыг бохирдохоос сэргийлэх зорилгоор хаягдал ус агуулах сангийн доторлогоог ус үл нэвчүүлэх материал бетоноор доторлож битүүмжлэх, эрчимтэй хур бороо, уруйн үерт өртөхөөс сэргийлж шаардлагатай арга хэмжээг авах
- Ахуйн бохир усны сан болон шугамын бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж ажиллах
- Хуурай хог хаягдлыг хадгалах, зайлуулахад усны нөөцийг бохирдуулахгүй газрыг сонгох
- Усны чанарын шинжилгээг тогтмол хугацаанд буюу улирал тутам мониторингийн цооногоос авч мэргэжлийн лабораторид өгч шинжлүүлж байх.
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэн, төслийн усны эх үүсвэр болсон гүний худагт эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, дэглэмийг мөрдөж ажиллах
- Техник хэрэгслийн тос, масло, шатахуун алдагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх
- Ус ашиглах гэрээ хийж зохих хугацаанд ус ашигласны төлбөрийг хийх ба жил бүр гэрээг шинэчлэх
- Зөвшөөрөлгүй гүний худаг өрөмдөж үйл ажиллагаандаа ашиглахыг хориглох
- Үйлдвэрлэлийн явцаас гарсан хог хаягдал, нүүрс, нефтийн бүтээгдэхүүний хаягдал хур бороо, хаврын шар усны үерт урсан орчныг бохирдуулахаас сэргийлэх

4.6. Ургамалан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд

- Олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг маршрутын дагуу тээвэрлэлт хийх
- Ургамлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх
- Ургамлын аймаг, ургамлын мониторингийн судалгааны төсөл хэрэгжүүлэх

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

- Төслийн үндсэн үйл ажиллагаа болох хөрс хуулалтад өнгөн хэсгийн ургамал устаж үгүй болох, овоолго, барилга байгууламжийн доорх ургамал дарагдах, авто замд арчигдах зэрэг сөрөг нөлөөллийг бууруулахын тулд биологийн нөхөн сэргээлтийг цаг алдалгүй чанартай хийх
- Уурхайн олборлолт явуулж байгаа хэсгийн салхины доод талын болон замын ойролцоох газрууд тоосны хуримтлал үүсч ургамлыг устгах аюултай тул зам талбайг тогтмол услах
- Шатах тослох материал, машин механизмын засварын газар болон уурхайн тосгоны газрыг эмх цэгцтэй зохион байгуулах, орчныг бохирдуулахгүй байх талаар анхаарах
- Зам талбай, нөхөн сэргээсэн талбайн усалгаа тордолтыг сайн хийх
- Ургамлын доройтол үүсч бий болох магадлалтай газруудад хил хязгаар тогтоох, шимт хөрсний хуулалт, хадгалалт, хамгаалалтыг стандартын дагуу гүйцэтгэх
- Төслийн хэрэгжилтээс үүдэлтэй хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, тээвэрлэх бүхий л үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартыг баримтлах

4.7. Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байлгах үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Ил уурхай нь зөвхөн ашиглалт явуулж буй талбайд бус түүний эргэн тойрныг хамарсан радуст нөлөөлөл үзүүлж байдаг. Иймд уурхай орчмын амьтдын тоо толгой, байршил, шилжилт хөдөлгөөн, тэдгээрийн төрөл зүйл устах болон амьдралынх нь хэвийн үйл ажиллагаа алдагдаж буй эсэхэд ажиглалт хийж, хариу арга хэмжээ авах
- Тоосжилтыг бууруулж хуурайшилт ихтэй үед зам талбайг услах
- Хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт хадгалах, амьтны бэлчээр, гол мөрний ойролцоо газар хаяхаас зайлхийх

4.8. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалт зүйлд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах

Төслийн талбай нь ЗГ-ын 2012 оны 194-р тогтоолоор баталсан гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн зааг, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хил заагтай тус тус давхцалгүй. Төсөл хэрэгжүүлэгчийнмн зүгээс түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, түүнд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаандаа Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын соёлын өвийг хамгаалах тухай хуулийг баримтлан ажиллах шаардлагатай. Тухайлбал төслийн талбайд газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн мэргэжлийн байгууллагад нэн даруй мэдэгдэх нь зүйтэй.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь Монгол улсын хууль, тогтоол, дүрэм, журам, стандартыг баримталж, хариуцлагатай уул уурхайг Монгол улсад хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулахын төлөө ажилладаг. Түүнчлэн олон улсын уул уурхайн компаниудын стандарт,

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

зөвлөгөө зөвлөмж, олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа тусгадаг. Компанийн байгаль орчны бодлогын хүрээнд байгаль орчны менежментийн системийг боловсруулж, нэвтрүүлж эхэлж байна. Одоогийн байдлаар байгаль орчны чиглэлээр байгууллагын 10-н дотоод журам батлагдсан бөгөөд тэдгээрийг “Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөж ажиллаж байна.

1. Байгаль орчны бодлого, менежмент
2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
3. Байгаль орчны мониторинг
4. Байгаль орчны нөхөн сэргээлт
5. Байгаль орчны аудит
6. Хог хаягдлын менежмент

Орчны хяналт шинжилгээний нэгдсэн хөтөлбөрт тусгагдсан ажлыг хийхдээ Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны хяналт Шинжилгээний албаны “Байгаль орчны лабораторитой хамтран ажиллах” гэрээг байгуулж ажиллахаар төлөвлөж байна. Мөн мэргэжлийн байгууллагуудын туслалцааг авч, магадлан итгэмжлэгдсэн лабораториудад УСУГ-ын усны лаборатори, Геологийн төв лабораториудаар шинжилгээ хийлгэж ажиллахаар төлөвлөсөн.

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг цогц байдлаар шийдвэрлэх арга зам, түүнд шаардагдах зардлыг хамруулан тусгасан.

Улаан-Овоогийн уурхайн 2024 оны “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийг Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 9 ба 10 дугаар зүйл ба байгаль орчныг хамгаалах бусад багц хууль болон холбогдох журам, зааврууд болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тавьсан шаардлагууд дээр үндэслэн боловсруулсан. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг доорх хүснэгт дээр харууллаа.

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар						
Уурхайн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ ихсэх	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замыг услах арга хэмжээ авах	Уурхайн замууд	Дотоод төлөвлөлтөөр		2024 он	“Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Агаарын тухай хууль” MNS 4585:2016 Агаарын чанар. Ерөнхий шаардлага Монголын агаарын чанарын стандарт MNS 3384:82, MNS 3383:19828, Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томьёо, тодорхойлолт
	Техник, тоног төхөөрөмжийг тогтмол оношилгоонд оруулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх	Тээврийн хэрэгсэл	Дотоод төлөвлөлтөөр			
	Агаар орчны шинжилгээг мэргэжилийн байгууллагад дээж өгч гарсан хариуд үндэслэн арга хэмжээг авах	Агаар орчин	ОХШХ-т тусгав.			
	Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх, өгөршлийн бүсэд халалт үүссэн үед галыг даруй дарах	Уурхайн талбай, нүүрсний агуулах	Дотоод төлөвлөлтөөр			
	Уурхайн дотоод тээврийн зам болон гадаад тээврийн замд хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Уурхай зам	50.0	200.0	2024 он	
Газрын гадарга, хөрс						
Ахуйн болон шатах, тослох материалын хаягдлаар өнгөн хөрс бохирдох	Засварын газар болон хог хаягдлын цэгүүдийг бетонон хучилттай болгох	Засварын газар болон хог хаягдлын цэгүүд	2,500.0		2024 он	MNS 5916:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
Хөрсөнд шатах тослох материалын бодис асгарснаар өнгөн хөрс бохирдох	Хөрсөнд шатах, тослох материал болон бусад бодис асгарч алдагдсан тохиолдолд нэн даруй цэвэрлэх арга хэмжээг авах	Ажлын талбай	Дотоод төлөвлөлтөөр			

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

Хөрс бохирдох, доройтох	Хөрсний хяналт мониторингийг БОННУ-ний тайланд заасан цэг болон үзүүлэлтээр шинжлүүлэх	Уурхайн талбай	ОХШХ-г тусгав.	2024 он	MNS 5916:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
Төлөвлөгдөөгүй замаар тээвэр хийж олон салаа зам гаргаж өнгөн хөрс доройтуулах	Олон салаа зам гаргахаас сэргийлэх хаалт, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төлөвлөгдөөгүй замаар тээвэр хийсэн олон салаа зам	300.0	2024 он	MNS 5916:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
Шимт хөрсний нөөц, ургамлын нөмрөг доройтох	Хөрс сайжруулах арга хэмжээ авах	Техникийн нөхөн сэргээлт хийх талбайд	500.0	2024 он	MNS 5916:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
Ахуйн болон бусад энгийн хог хаягдлаар хөрс бохирдох	Хогийн цэгийг тохижуулах	Уурхайн түр хогийн цэг	500.0	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Хог хаягдлын тухай” хууль MNS5850:2019
Ургамлан нөмрөг					
Ургамлан нөмрөг устгах, доройтох	Олон салаа зам гарахгүй байх, тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Уурхай орчмын талбай	Дотоод төлөвлөлтөөр	2024 он	БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт “УУ-н үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал Эвдэрсэн газрыг ургамалжуулах”
	Шатах тослох материал, машин механизмын засвартай газар орчныг бохирдуулахгүй байхаар анхаарах	Кемп, уурхайн орчинд			
	Тоосны хуримтлал үүсэж ургамлыг устгах аюултай тул зам талбайг тогтмол услах	Уурхайн олборлолт явуулж байгаа талбай	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэсэгт оруулав		

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

	Зам талбай, нөхөн сэргээсэн талбайн усалгаа тордолтыг сайн хийх	Нөхөн сэргээсэн талбай	Дотоод төлөвлөлтөөр	2024 он	Техникийн ерөнхий шаардлага MNS5918:2018
	Төслийн хэрэгжилтээс үүдэлтэй хог хаягдлыг ангилан ялгах, цэгийг бий болгох	Төслийн хогийн цэг болон түр хогийн цэгүүд	Дотоод төлөвлөлтөөр	2024 он	
Усан орчин					
Уурхайн малталтад орж ирэх газрын доорх усны бохирдол үүсэх	Ус ашиглуулах дүгнэлтийг Усны газраар гаргуулах	Холбогдох бичиг баримт	Дотоод төлөвлөлтөөр	2024	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 6148:2010 Газрын доор усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Гүний худагт эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, дэглэмийг мөрдөж ажиллах	Төслийн эх үүсвэр болсон гүний худаг	600.0		
	Гүний худагт тоолуур суулгах	Гүний худаг	250.0		
Усны найрлага чанарт өөрчлөлт орох	Усны чанарын шинжилгээг тогтмол хугацаанд буюу улирал тутам мониторингийн цооногоос авч мэргэжлийн лабораторид өгч шинжлүүлж байх.	Кемп болон уурхайн усны хэрэгцээг хангадаг гүний худаг	500.0	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 6148:2010 Газрын доор усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Гүний усны нөөцөд өөрчлөлт орох	Шүүрлийн усыг соруулах, тоолуур тавьх	Ус соруулах зумп	3,000.0	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 6148:2010 Газрын доор усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Бага гүнд орших уст давхарга бохирдох. Усны хэрэглээ ихсэх төслийн талбай,	Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хог хаягдал, нүүрс, нефтийн бүтээгдэхүүний хаягдал хур бороо, хаврын шар усны үерт урсан орчныг бохирдуулахаас сэргийлэх	Кемп болон уурхайн усны хэрэгцээг хангадаг гүний худаг	300.0	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Хог хаягдлын тухай” хууль MNS5850:2008

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

түүний орчмын газар					
Амьтан					
Амьдрах орчноо солих, дайчих, тоо толгой буурах	Амьтдын амвдрах орныг хамгаалах үүднээс тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Уурхайн орчмын ан амьтад	200.0	2024 он	“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Амьтны тухай” хууль
Амьдын бэлчээр болон амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэх	Хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт хадгалах, амьтны бэлчээр, гол мөрний ойролцоо газар хаяхаас зайлхийх, хогийн цэг бий болгох	Амьтдын бэлчээр амьдрах орчин	Дотоод төлөвлөлтөөр	2024 он	
Нийт			8,850.0 төгрөг		

7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (ТЕХНОЛОГИЙН, БИОЛОГИЙН)

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт

2024 онд уулын ажлын төлөвлөлтөөр уурхай, овоолго, зам талбай зэргээс нийт 142.9 мян.мкв талбай өртөхөөр байна.

Хүснэгт 7. 2024 онд эвдрэлд өртөх талбайн хэмжээ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Уурхайн ухалгад өртөх талбай	м ²	72,656.0
2	Хөрсний овоолгод өртөх талбай	м ²	70,308.0
3	Зам, барилгын ажлын явцад өртөх талбай	м ²	-
4	Нийт шимт хөрс хуулах талбай	м ²	142,964.6
5	Шимт хөрс хуулах зузаан /дунджаар/	м	0.3-0.5
6	Нийт хуулах шимт хөрсний хэмжээ	мян.м ³	71.4

2024 онд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд үржил шимт хөрс хуулах, хадгалах ажил бага хэмжээгээр хийгдэх бөгөөд уурхайн ашиглалт эхний шатанд явж байгаа тул эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хэмжээ бага байна.

Хоосон чулуулгийн овоолго

2024 онд сийрэгжилт тооцсоноор 707.25 мян. м3 хоосон чулуулаг овоолох ажил хийнэ. Уг хаягдал чулуулгийг ТЭЗҮ-ийн дагуу хаягдлын овоолгын зүүн урд хэсэгт дүүргэлт хийн 810 м түвшинд хүргэнэ.

Шимт хөрсний овоолго

Хөрсний овоолго үүсгэх талбайн шимт хөрсийг 0.5-0.7 метр зузаантай хуулж шимт хөрсний овоолго байгуулна. Шимт хөрсийг нөхөн сэргээлтэд зориулан хураах тул нөхөн сэргээлт хийх овоолго болон бусад эвдэгдсэн талбайтай ойр хураана. 2024 онд нийт 21.7 га эвдэгдэх талбайгаас 65.1 мян.м³ шимт хөрс хуулж уурхайн баруун хойно байрлах хуучин шимт хөрсний овоолгын дээр нэмж байршуулна. Овоолгын ажилд D8R бульдозерыг ашиглана.

Биологийн нөхөн сэргээлт

Шимт хөрсийг хадгалах ургамалжуулах, хөрс ургамал доройтсон газрын үржил шимийг сэргээх зорилгоор олон наст ургамлын үр тарих ажил энэ онд хийгдэнэ.

**“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024**

Хүснэгт 8. 2024 онд хийгдэх нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн бичиг баримт	
1	Техникийн нөхөн сэргээлт	Хөрс хуулалт	мян.м ³	71.4	70.0	5,000.0	2024 он	MNS 5917:2008 Уул уурхай үйлдвэрлэлийн ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	
2	Биологийн нөхөн сэргээлт	Олон наст ургамалын үр	кг	50	100.0	5,000.0		MNS 5916:2008 газар шорооны ажлыг үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт	
Нийт				10, 000.0 мян.төг					

8. ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Монгол улсын ерөнхийлөгийн санаачилсан Тэрбум мод үндэсний төслийн хүрээнд орон нутагт мод тарих ажлыг орон нутгийн байгаль орчны газартай хамтран хэрэгжүүлнэ. Энэ ажлын зардалд нийт 9 сая төгрөг тусгав.

**“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024**

9. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн БОННУ-ний тайланд төсөл хэрэгжих эхний 2 жилд эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхээр оруулсан бөгөөд энэхүү ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт эвдэгдэж орхигдсон 2 хэсэг нийт 0.9 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Дараах хүснэгт болон зургуудад мэдээллийг оруулав.

Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа
1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээх зорилтын дагуу нөхөн сэргээлт хийх	Хаягдсан кареарт техникийн нөхөн сэргээлт хийх	Түшиг сум	0.9 га	8,080.0	2024 онд

Хүснэгт 10. Хаягдсан карьерын координат

№	Өргөрөг	Уртраг
1	50°20'16.7	105°04'06.6
2	50°20'15.1	105°04'06.8
3	50°20'13.0	105°04'08.0
4	50°20'15.7	105°04'08.3
5	50°20'17.5	105°04'08.3
6	50°20'17.1	105°04'07.2
7	50°20'15.4	105°04'10.1
8	50°20'18.7	105°04'04.5
9	50°20'17.8	105°04'05.7
10	50°20'20.4	105°04'04.8
11	50°20'21.5	105°04'04.9
12	50°20'21.4	105°04'06.3
13	50°20'20.1	105°04'08.1
14	50°20'18.2	105°04'08.0

Зураг 4. Эвдрэлд орсон газар



10. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн хүрээнд айл өрхийг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.

11. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хайгуулын ажлын явцад, уурхайн лизенцийн талбайгаас нийт 13 дурсгал илрүүлэн бүртгэн тэмдэглэж авсны 6 нь хүрэл зэвсгийн үед (МЭӨ XII-IV зуун), 2 нь дундад зууны үед (МЭ X-XIV зуун) холбогдох булш байгаа бол он цаг тодорхойлох боломжгүй (хэлбэр нь тодорхойгүй) булш 5 байна. Энэхүү хайгуулаар олдсон дурсгалууд нь эртний түүхийн хосгүй дурсгалууд бөгөөд эдгээрийг түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17.10, 17.12 болон “Монгол улсын нутаг дэвсгэр дээр археологи, палеонтологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 2.4, 2.5 дугаар заалтуудыг үндэслэн түүх-археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтад авч анхааран, зайлшгүй шаардлагатай тохиолдолд, чөлөөлөх арга хэмжээ авна.

Хүснэгт 11. Археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтад авах арга хэмжээ

Нөлөөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг /	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Түүх соёлын дурсгал	Уурхайн ажлын явцад ямар нэг археологи, палеологийн олдвор илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандаж, авран хамгаалах ажил зохион байгуулах	Тусгай зөвшөөрөл бүхий талбай	5,000.0		Уурхайн газар шорооны ажил явагдах үед	Соёлын өвийг хамгаалах тухай хууль Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.9 Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам
Хайгуулын ажлын явцад илэрсэн дурсгалууд	Олдвор илэрсэн газруудад таних тэмдэг байршуулах, шаардлагатай тохиолдолд хашаажуулах	Тусгай зөвшөөрөл бүхий талбай	2,000.0			
Нийт				7,000.0		

12. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын хөрс, барилга байгууламж эвдрэх, уурхай үерийн усанд автах	Ил уурхайн гадуур үерийн хамгаалалтын далан хийх, засаж сайжруулах		Дотоод төлөвлөлтөөр			
Ой хээрийн гүймэр гарах,	Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх Тэсэрч дэлбэрч болох ахуйн хэрэглэлүүд болон тослох материалын хадгалалт, асгаралтыг, хянаж байх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах	Уурхай болон кэмп орчин	1,000.0	1,000.0	Уурхайн газар шорооны ажил явагдах үед	Гамшгаас хамгаалах тухай “Галын аюулгүй байдлын тухай”
Шатах тослох материал шатах эрсдэлээс сэргийлэх	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах саванд хадгалах	Уурхай орчинд	500.0	500.0	2024 он	Газрын тосны бүтээгдэхүүний тухай “Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах”
Нийт			1,500.0			

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, ариилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг (мян,төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хог хаягдлын ангилан ялгалтыг тогтмол хийх.	Ашиглалтын талбай, кемп, ажлын байруудад	Өдөр тутмын үйл ажиллагаа			<ul style="list-style-type: none"> Хог хаягдлын тухай хууль Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага. БОАЖСайдын 2018 оны А/443 дугаар тушаал. 	
2		Хог хаягдлын түр цэг байгуулах		600.0	600.0	2024 он		
3		Хогийн ангилан ялгах сав байршуулах		1,400.0				
4	Хог хаягдлын эх үүсвэр дээр нь ангилан ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдлыг эх үүсвэр, төрлөөр нь ангилж кодчилон зэрэглэл тогтоох	“Юу Жи Эл Интерпрайзис” ХХК	500.0	500.0	Жил бүр	<ul style="list-style-type: none"> Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар ттушаал Хог хаягдлын тухай хууль Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/368 дугаар тушаал 	
5		Хог хаягдлын тооллого хийж, эх үүсвэр тус бүрээс жилд үүсэх хаягдлын төрөл, тоо хэмжээг нарийвчлан тогтоох		Гэрээнд заасны дагуу				
6		Тээврийн хэрэгслийн аккумулятор, ажилласан тос зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг холбогдох журмын дагуу цуглуулж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг холбогдох журмын дагуу цуглуулж, даних боловсруулах үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж компаниудтай гэрээ байгуулан хүлээлгэн өгөх		Уурхайн бүх ажиллагсад				1,000.0
7		Ажиллагсад хог хаягдлын хууль, эрхзүйн орчин, хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах		Тухайн жилийн дүн (мян.төг)			3,500.0	

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн зүгээс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл тэдгээрийн тархалтыг хянах, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг хянах, байгаль орчны бохирдол явагдсан хэсгийг илрүүлэх, сөрөг нөлөөллийг багасгах нэмэлт арга хэмжээ авах зорилгоор мониторингийн үйл ажиллагааг явуулах зорилготой. Мониторинг нь байнгын ажиглалт, шинжилгээгээр гарсан үзүүлэлтүүдийн хяналт тэдгээрийн бие даасан үнэлгээ болон хэтийн төлөв байдлыг урьдчилан таамаглах цогц үйл ажиллагаа юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Юү Жи Эл Интерпрайзис” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаа явуулахад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно.

Хяналт шинжилгээ, ажиглалт судалгааны дүнг шинжлэн дүгнэж төслийн тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын тайланд хавсарган холбогдох хяналтын байгууллагуудад хүргүүлнэ. Мөн цаашид Сэлэнгэ аймгийн ус цаг уурын шинжилгээний лабораторитой хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

БО-ны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Шинжилгээ явуулах төрөл, арга, хэлбэр	Байршил	Баримтлах стандарт	Арга, аргачлал хэрэглэх тоног төхөөрөмж	Давтамж хугацаа	Нэг жилийн зардал (мян.төг)
Агаарын чанар	Орчны тоосжилт	PM2.5, PM10	Уурхайн дотор болон түүний орчимд тоосжилт хянах 5 цэгт буюу	MNS 4585:2016	Тоосны уналтыг хэмжих багаж, лабораторийн шинжилгээ	2 удаа	1,000.0
	Агаар дахь хорт хийн шинжилгээ	Азотын давхар исэл (NO ₂); Хүхэрлэг хий (SO ₂);	Уурхайн карьер дотор, Дотоод тээврийн замын орчинд, ННАХ орчим, Засварын газрын орчинд, Кемпийн орчинд	MNS 4585:2016	Лабораторийн шинжилгээ	2 удаа	
Хөрсний чанар	Физик болон химийн үзүүлэлт	Элэгдэл, ялзмаг, рН, CaCO ₃ , Цахилгаан дамжуулах чанар, P ₂ O ₅ , K ₂ O, Механик бүтэц	Уурхайн шимт хөрсний овоолго, уурхайн талбайн дотор нөлөөлөлд өртөөгүй талбайд, кемпийн орчимд, Уурхайн талбайн гадна	Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 3298:1991	Лабораторийн шинжилгээ	2 удаа	1,000.0
	Хөрсний бохирдол	Хүнд металлууд болон нефть, нефтийн бүтээгдэхүүний бохирдол	Засварын газар, хогийн цэг, уурхайн авто зогсоол, кемпийн гадна зогсоол, ариун цэврийн байгууламж, эрүүл хөрс	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элémentийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019			
Усан орчин	Хими болон физикийн үзүүлэлт	рН, цахилгаан дамжуулах чадвар, өнгө, хатуулаг, хлорид, аммони, нитрит, нитрат, форгофосфат, гидрокарбонат, сульфат, Ca, Mg, Na, K	Унд ахуйд хэрэглэж буй гүний худаг болон байгальд нийлүүлэх усанд	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900:2018	Усны дээжний сав, лабораторийн шинжилгээ	4 удаа	800.0

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

	Усны чанар	Усны хүнд элементүүд	Шүүрлийн ус, тунаах нуурын ус, хэрэглээний худгийн ус	Байгаль орчин. Усны чанар MNS 6837:2020	Лабораторийн шинжилгээ	1 удаа	
	Эрүүл ахуйн	Бактерлоги болон микро биологийн	Ашиглагдаж буй өрөмдөл худгийн усанд	Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: MNS 5667-1:2002	Усны дээж авах тусгай ариутгасан сав, лабортарийн шинжилгээ	1 удаа	
Ургама лан бүрхэвч	Хяналт шинжилгээ	Ургмалан аймаг, ургамлан нөмрөгийн өсөлт, хөгжил	Хяналтын цэгт тогтоох	-	Дижитал зургийн аппарат, туузан метр, хээрийн судалгааны мэдээ цуглуулах маягт	1 удаа	678.0
Амьтан	Судалгаа шинжилгээ	Төслийн талбай орчмын хөхтөн амьтан, хэвлээр явагч болон шувуудын ажиглалт	Төслийн талбай болон нөлөөллийн бүсэд	Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хөхтөн амьтдад тавих тусгай шаардлага MNS 6944:2021 Шувуу MNS6945:2021 Хоёр нутагтан, мөлхөгчид MNS 6946:2021	Ажиглалт, судалгааны арга барилыг авч хэрэгжүүлэх	Жилд 6-8-р сард 1 удаа	700.0
ОХШХ-нийт дүн:				4,178.0 мян.төг			

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2024

14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨ					
№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Ажиллагсадыг өвлийн тусгай хувцас хэрэгслээр бүрэн хангах	Дотоод төлөвлөлтөөр	2024 оны 10-р сараас өмнө	Хангамжийн ажилтан, ХАБАЭ мэргэжилтэн	Өвлийн бэлтгэл ажил эхлэхтэй холбогдуулан ажилчдын өвлийн хувцас хэрэглэлээр хангах захиалга хийгдэнэ
2	Ажлын байранд анхан шатны тусламж үйлчилгээний иж бүрэн багаж, хэрэгслийг авч байрлуулах	2,000.0	2024 онд	Эрүүл ахуйч, эмч, уурхайн удирдлага	Тухай бүрд нь шинэчлэх
3	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгаалал анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт нь байршуулах	1,000.0	2024 онд	ХАБЭА мэргэжилтэн	Галын хамгаалах хэрэгсэлийг нэг бүрчлэн шинэчлэл хийгдэнэ.
4	Байгаль орчны аудит хийлгэх	10,000.0	2024 онд	БО-ны мэргэжилтэн	Мэргэжлийн тусгай зөвшөөрлийн байгуулгаар гэрээ байгуулж хийлгэнэ
5	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулах	Дотоод төлөвлөлтөөр	2024 онд	ХАБЭА мэргэжилтэн	
Нийт		13,000.0			

15. БОМТ БИЕЛЭЛТИЙГ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн багийн иргэдийн хуралд Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Засаг даргын тамгын газар	БОМТ хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлэх, тайлагнах	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	БОМТ-ний дагуу хийгдсэн ажлын хэрэгжилт, түүнд санал авах	Сэлэнгэ аймгийн Түшиг сум

2024 онд зарцуулах Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Хүснэгт 17. Байгаль орчныг хамгаалах нийт зардал

№	БОМТ	Тухайн жилийн БОМТ-ний зардал (мян.төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8,850.0
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,500.0
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10,000.0
4	Тэрбум мод үндэсний хөтөлбөр	9,000.0
5	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	8,080.0
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
7	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	7,000.0
8	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,500.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	4,178.0
	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	13,000.0
	Нийт	65,108.0

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН ЗАРДАЛ

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн тухай.

“Юу Жи Эл интерпрайзис” ХХК нь Монгол улсын Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Усны тухай, Ус рашаан ашигласны төлбөрийн тухай хуулиуд болон бусад хууль, журмын дагуу төлбөр хураамжуудыг тухай бүрд төлж ажиллана.

Улаан-Овоогийн уурхайн Байгаль орчныг хамгаалах 2024 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд 21 074 000 төгрөг / хорин хоёр сая гурван зуун мянган төгрөг / төлөвлөсөн ба Сангийн Яамны Төрийн санд нээсэн 100900013406 дугаартай дансанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийн 50% болох 10 537 000 төгрөгийг байршуулна.

Газрын төлбөр

Улаан-Овоогийн уурхайн ажиллагаа явагдаж буй 106.4 га талбайг хашаажуулсан бөгөөд, Түшиг сумын Засаг даргын 2011 оны 57 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмших гэрээг 2011 онд шинэчлэн байгуулсан. Энэхүү гэрээнд тусгасны дагуу улирал тутамд 2.5 сая төлбөрийг төлж ажиллана.

Усны төлбөр

2024 онд уурхайн шүүрлийн шавхан зайлуулах дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаар гаргуулан уг дүгнэлт дээр үндэслэн гэрээ шинээр хийж шаардлагатай төлбөрийг Монгол улсын Усны тухай хуульд нийцүүлэн төлбөрийг төлж ажиллана.